

## САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЛИЙН АЛБАНД МЭДЭЭЛЭЛ ИРҮҮЛЭХ ЖУРАМ

### НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Энэ журмыг Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэгт заасны дагуу мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасан Мэдээлэх үүрэгтэй этгээд /цаашид “мэдээлэх үүрэгтэй этгээд” гэх/-ээс мөн хуулийн 7 дугаар зүйл, 9 дүгээр зүйлд заасан гүйлгээний талаарх мэдээлэл, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд заасан мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагаанд мөрдөнө.

1.3.Санхүүгийн мэдээллийн алба нь Мэдээлэх үүрэгтэй этгээдээс ирүүлсэн мэдээллийн талаарх нэгтгэсэн статистик мэдээллийг улирал тутамд гаргаж, Санхүүгийн мэдээллийн албаны цахим хуудсанд байршуулна.

### ХОЁР. ГҮЙЛГЭЭНИЙ ТАЛААР МЭДЭЭЛЭХ

2.1.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу дараах мэдээллийг энэ журмын нэгдүгээр хавсралтад тусгасан цахим хэлбэрээр холбогдох маягтын дагуу заасан хугацаанд Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлнэ:

2.1.1.20,0 (хорин) сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют) болон түүнээс дээш дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээний мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 5 (таван) өдрийн дотор ГоАМЛ (goAML) порталаар холбогдох маягтыг сонгон мэдээлнэ;

2.1.2.20,0 (хорин) сая төгрөг (түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют) болон түүнээс дээш дүнтэй гадаад төлбөр тооцооны гүйлгээний мэдээллийг гүйлгээ хийгдсэнээс хойш ажлын 5 (таван) өдрийн дотор ГоАМЛ (goAML) порталаар холбогдох маягтыг сонгон мэдээлнэ;

2.1.3.Хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлогыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой

холбоотой гэж сэжиглэсэн, эсхүл мэдсэн бол энэ тухай 24 цагийн дотор ГоАМЛ (goAML) порталаар холбогдох маягтыг сонгон мэдээлнэ .

2.2.Энэ журмын 2.1.3-т заасан сэжигтэй гүйлгээний талаарх мэдээллийг мэдээлэхэд ямар нэгэн хязгаарлалт, үнийн дүн хамаарахгүй.

2.3.Энэ журмын 2.1.1, 2.1.2-т заасны дагуу мэдээлсэн эсхүл мэдээлэх гэж байгаа гүйлгээ нь сэжигтэй гүйлгээ байна гэж үзсэн тохиолдолд уг гүйлгээг энэ журмын 2.1.3-т заасны дагуу дахин болон давхар мэдээлэх шаардлагагүй зөвхөн гүйлгээнээс бусад мэдээллийг холбогдох маягтын дагуу мэдээлнэ.

2.4.Энэ журмын 2.1.1, 2.1.2-т заагаагүй гүйлгээг сэжигтэй гүйлгээ байна гэж үзсэн тохиолдолд уг гүйлгээг энэ журмын 2.1.3-т заасны дагуу холбогдох маягтын дагуу мэдээлнэ.

2.5.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь энэ журмын 2.1.3-т заасны дагуу мэдээлсэн сэжигтэй гүйлгээтэй холбоотой шинэ мэдээлэл, өмнөх тайлангаар мэдээлээгүй үйл ажиллагаа, гүйлгээний хэв шинж, өөрчлөгдсөн нөхцөл байдал болон мэдээлснээс хойш болсон үйл явдлыг талаарх мэдээллийг Сэжигтэй гүйлгээний тайлангийн маягтаар дахин ГоАМЛ (goAML) порталаар холбогдох маягтыг сонгон мэдээлнэ.

2.6.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь ГоАМЛ (goAML) порталаар мэдээлэл ирүүлэхдээ xml формат эсвэл гараар тайлан оруулах сонголтын аль тохирохыг өөрөө сонгож мэдээлнэ. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь xml форматаар тайлан мэдээлэх бол тайланг тухайн формат руу хөрвүүлэх програм, хөрвүүлэгчийг өөрөө хариуцан боловсруулна.

## ГУРАВ. СЭЖИГТЭЙ ГҮЙЛГЭЭНИЙ ТУХАЙ НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ

3.1.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 9.2-т заасны дагуу Мэдээлэх үүрэгтэй этгээд нь сэжигтэй гүйлгээтэй холбогдох дараах нэмэлт мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд ирүүлнэ:

3.1.1.Сэжигтэй гүйлгээтэй холбогдсон этгээдийн дансны хуулбар;

3.1.2.Сэжигтэй гүйлгээтэй холбогдсон этгээдийн данс нээхэд ашигласан бичиг баримтын хуулбар;

3.1.3. Банкны харилцагчийн эрсдэлийг үнэлсэн баримт бичиг;

3.1.4. Холбогдох бусад нэмэлт мэдээлэл.

3.2.Санхүүгийн мэдээллийн алба нь Мэдээлэх үүрэгтэй этгээдээс сэжигтэй гүйлгээтэй холбогдох нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг ГоАМЛ (goAML) порталаар холбогдох маягтын дагуу хүргүүлнэ.

3.3.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь энэ журмын 3.1-д заасан мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанаас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн мэдээллийн хэмжээнээс хамааран ажлын 1-5 өдрийн дотор ГоАМЛ (goAML) порталгаар хариу өгөх үүрэгтэй.

#### ДӨРӨВ. ГоАМЛ (goAML) ПОРТАЛЫГ АШИГЛАХ

4.1. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь байгууллага болон тайлан хариуцсан хэрэглэгчээр ГоАМЛ (goAML) порталд бүртгүүлсэн байна. Тайлан хариуцсан хэрэглэгчээр бүртгүүлсэн ажилтан солигдсон үед шинэ хэрэглэгч бүртгүүлж, өмнөх хэрэглэгчийн эрхийг хаах арга хэмжээг авна.

4.3.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь ГоАМЛ (goAML) порталыг Санхүүгийн мэдээллийн албанаас гаргасан ГоАМЛ (goAML) порталыг ашиглах хэрэглэгчийн гарын авлагын дагуу ашиглана.

4.4.Санхүүгийн мэдээллийн алба нь Мэдээлэх үүрэгтэй этгээдээс оруулсан тайлангийн төлөвийн талаарх мэдэгдлийг ГоАМЛ (goAML) порталын мессеж болон Мэдээлэх үүрэгтэй этгээдийн хэрэглэгчийн бүртгүүлсэн цахим шуудан руу илгээнэ.

4.5.Санхүүгийн мэдээллийн алба нь мэдээлэл авах хүсэлт болон бусад мессежийг Мэдээлэх үүрэгтэй этгээдийн ГоАМЛ (goAML) порталын мессеж руу тухай бүр хүргүүлнэ.

4.6.Мэдээлэх үүрэгтэй этгээдийн ГоАМЛ (goAML) порталын хэрэглэгч нь тайлангийн төлөв, Санхүүгийн мэдээллийн албанаас хүргүүлсэн мэдээлэл авах хүсэлт болон бусад мессежийг тогтмол шалгаж байх үүрэгтэй.

4.7.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь ГоАМЛ (goAML) порталд алдаатай тайлан оруулснаа тайлан хянагдаагүй үед мэдсэн бол Санхүүгийн мэдээллийн албатай холбогдож, хянагдаагүй тайланг буцаалган засаж оруулах арга хэмжээ авна.

4.8.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь ГоАМЛ (goAML) порталд алдаатай тайлан оруулснаа тайлан хянагдсаны дараа мэдсэн бол тайланг дахин оруулах хүсэлтийг Санхүүгийн мэдээллийн албаны [fiu@mongolbank.mn](mailto:fiu@mongolbank.mn) хаяг руу илгээнэ. Тайланг дахин оруулах хүсэлтэд тайланг мэдээлсэн огноо, тайлангийн дугаар, тайлангийн нэр, гүйлгээний нийт тоо болон ямар учир шалтгаанаар тайлан дахин оруулах хүсэлт гаргаж байгаа талаар тодорхой бичсэн байна.

4.9.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь хуульд заасан мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанаас гаргасан ГоАМЛ (goAML) порталыг ашиглах хэрэглэгчийн гарын авлагын дагуу холбогдох маягтад бүрэн, үнэн зөв бөглөж, хуульд заасан хугацаанд мэдээлэх үүрэгтэй.

4.10.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь сэжигтэй гүйлгээтэй холбогдох нэмэлт мэдээлэл авах хүсэлтэд энэ журмын 3.3-д заасан хугацаанд, ГоАМЛ (goAML) порталгаар хариу өгөх үүрэгтэй. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь Санхүүгийн мэдээллийн албанаас хүргүүлсэн нэмэлт

мэдээлэл авах хүсэлтийг ГоАМЛ (goAML) порталд шалгаагүй нь энэ журмын 3.3-т заасан хугацааг хойшлуулах үндэслэл болохгүй.

## ТАВ. МЭДЭЭЛЛИЙН НУУЦЛАЛ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ

5.1.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь энэ журмын 2, 3 дугаар зүйлд заасан мэдээллийг бэлтгэсэн, мэдээлэх гэж байгаа, мэдээлсэн, шилжүүлсэн тухай мэдээлэл, тэдгээрийн хуулбарыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хуульд заасны дагуу хадгална.

5.2.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь энэ журмын 2, 3 дугаар зүйлд заасан мэдээллийг Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн ажилтны аюулгүй байдал, нууцлалыг хангах арга хэмжээг авч ажиллана.

5.3.Энэ журмын 2, 3 дугаар зүйлд заасан мэдээллийг мэдээлсэн, түүнтэй танилцсан ажилтанд дараах үйл ажиллагааг хориглоно:

5.3.1.Мэдээлэлд холбогдсон харилцагч, хувь хүн, хуулийн этгээдэд мэдээллийг бэлтгэсэн, мэдээлэх гэж байгаа эсхүл мэдээлсэн тухай мэдэгдэх;

5.3.2.Мэдээллийг бэлтгэсэн, мэдээлэх гэж байгаа эсхүл мэдээлсэн тухай хуульд заасан эрх бүхий байгууллага, эрх бүхий албан тушаалтнаас өөр этгээдэд мэдээлэх, задруулах.

5.4.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь мэдээлэл алдагдахаас сэргийлэх зохицуулалтыг дотоод хяналтын хөтөлбөртөө тусгасан байна.

5.5.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь ГоАМЛ (goAML) порталыг ашиглах хэрэглэгчийн нэр, нууц үгийг бусдад дамжуулахгүй байх, хэрэглэгч байхаа больсноос хойш ашиглахгүй байх болон Санхүүгийн мэдээллийн албанаас гаргасан ГоАМЛ (goAML) порталыг ашиглах хэрэглэгчийн гарын авлагад тусгаснаас өөр зорилгоор ашиглахгүй байх үүрэгтэй.

## ЗУРГАА. ХАРИУЦЛАГА

6.1.Мэдээлэх үүрэгтэй этгээд нь Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн мэдээллийн үнэн зөв, бүрэн байдлыг хариуцна. Мэдээлэх үүрэгтэй этгээд нь алдаатай, дутуу, буруу мэдээлэл ирүүлсэн болон энэ журам болон бусад холбогдох хууль, журмын шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

-----oOo-----

### 1. Талбар “report”

Нэр	Тайлбар	Төрөл
rentity_id	Мэдээлэх үүрэгтэй этгээд/Байгууллагын дугаар	Бүхэл тоо
rentity_branch	МҮЭ-ийн салбар	Текст 255 тэмдэгт
submission_code	Илгээсэн код	Сонголт
report_code	Тайлангийн код	Сонголт
entity_reference	МҮЭ-ийн дугаар	Текст 255 тэмдэгт
fiu_ref_number	СМА дугаар	Текст 255 тэмдэгт
submission_date	Хамаарах огноо	Огноо
currency_code_local	Төгрөгийн дүн	Талбар “Currency_type”
reporting_person	Тайлан бэлтгэсэн	Талбар “t_person_registration_in_report”
Location	МҮЭ-ийн хаяг	Талбар “t_address”
Reason	Үндэслэл	Текст 4000 тэмдэгт
Action	Тайлбар/Арга хэмжээ	Текст 4000 тэмдэгт

### 1.2. Дэд талбар “report\_indicators”

Нэр	Тайлбар	Төрөл
Indicator	Ангилал	Сонголт

### 2. Талбар “transaction”

Нэр	Тайлбар	Төрөл
transactionnumber	Гүйлгээний дугаар	50 тэмдэгт
internal_ref_number	Дотоод дугаар	50 тэмдэгт
transaction_location	Байршил	255 тэмдэгт
transaction_description	Гүйлгээний утга	4000 тэмдэгт
date_transaction	Огноо	DateTime
teller	Теллер	20 тэмдэгт
authorized	Зөвшөөрсөн	20 тэмдэгт
late_deposit	Оройны депозит	Булеан
date_posting	Гүйцэтгэсэн огноо	Огноо
value_date	Гүйлгээ хийсэн огноо	Огноо
transmode_code	Гүйлгээний хэлбэр	Сонголт
transmode_comment	Тайлбар	50 тэмдэгт

<b>amount_local</b>	Төгрөгийн дүн	Бутархай тоо
---------------------	---------------	--------------

### 3. Талбар “Activity”

Нэр	Тайлбар	Төрөл
<b>Report_parties</b>	Тайлангийн талууд	-
<b>report_party</b>	Тайлангийн тал	Талбар “ <b>report_party</b> ”
<b>goods_service</b>	Бараа үйлчилгээ	Талбар “ <b>t_trans_item</b> ”

### 4. Талбар “t\_from\_my\_client”

Нэр	Тайлбар	Төрөл
<b>from_funds_code</b>	Хөрөнгийн хэлбэр	Сонголт
<b>from_funds_comment</b>	Тайлбар	Текст 255 тэмдэгт
<b>from_foreign_currency</b>	Гадаадад валют	Талбар “ <b>t_foreign_currency</b> ”
<b>t_conductor</b>	Гүйлгээ гүйцэтгэгч	Талбар “ <b>t_person_my_client</b> ”
<b>from_account</b>	Данснаас	Талбар “ <b>t_account_my_client</b> ”
<b>from_person</b>	Хүнээс	Талбар “ <b>t_person_my_client</b> ”
<b>from_entity</b>	Этгээдээс	Талбар “ <b>t_entity_my_client</b> ”
<b>from_country</b>	Улсаас	Сонголт

### 5. Талбар “t\_from”

Нэр	Тайлбар	Төрөл
<b>from_funds_code</b>	Хөрөнгийн хэлбэр	Сонголт
<b>from_funds_comment</b>	Тайлбар	255 тэмдэгт
<b>from_foreign_currency</b>	Гадаадад валют	Талбар “ <b>t_foreign_currency</b> ”
<b>t_conductor</b>	Гүйлгээ гүйцэтгэгч	Талбар “ <b>t_person</b> ”
<b>from_account</b>	Данснаас	Талбар “ <b>t_account</b> ”
<b>from_person</b>	Хүнээс	Талбар “ <b>t_person</b> ”
<b>from_entity</b>	Этгээдээс	Талбар “ <b>t_entity</b> ”
<b>from_country</b>	Улсаас	Сонголт

### 6. Талбар “t\_to\_my\_client”

Нэр	Тайлбар	Төрөл
<b>to_funds_code</b>	Хөрөнгийн хэлбэр	Сонголт
<b>to_funds_comment</b>	Тайлбар	255 тэмдэгт
<b>to_foreign_currency</b>	Гадаадад валют	Талбар “ <b>t_foreign_currency</b> ”
<b>to_account</b>	Гүйлгээ гүйцэтгэгч	Талбар “ <b>t_account_my_client</b> ”
<b>to_person</b>	Хүнээс	Талбар “ <b>t_account_my_client</b> ”
<b>to_entity</b>	Этгээдээс	Талбар “ <b>t_entity_my_client</b> ”
<b>to_country</b>	Улсаас	Сонголт

## 7. Талбар “t\_to”

Нэр	Тайлбар	Төрөл
<b>to_funds_code</b>	Хөрөнгийн хэлбэр	Сонголт
<b>to_funds_comment</b>	Тайлбар	255 тэмдэгт
to_foreign_currency	Гадаадад валют	Талбар “t_foreign_currency”
<b>to_account</b>	Гүйлгээ гүйцэтгэгч	Талбар “t_account”
<b>to_person</b>	Данснаас	Талбар “t_account”
<b>to_entity</b>	Этгээдээс	Талбар “t_entity”
<b>to_country</b>	Улсаас	Сонголт

## 8. Дэд талбар “goods\_services”

Нэр	Тайлбар	Төрөл
<b>Item_type</b>	Төрөл	Талбар “trans_item_type”
Item_make	Үйлдвэрлэгч	255 тэмдэгт
<b>description</b>	Тайлбар	4000 тэмдэгт
previously_registered_to	Өмнө нь бүртгүүлсэн	500 тэмдэгт
presently_registered_to	Одоо бүртгэлтэй байгаа	500 тэмдэгт
estimated_value	Зах зээлийн үнэлгээ	Бутархай тоо
status_code	Төрөл	Сонголт
status_comments	Тайлбар	500 тэмдэгт
disposed_value	Зарсан дүн	Бутархай тоо
Currency_code	Валют	Сонголт
size	Хэмжээ	Бутархай тоо
address	Хаяг	Талбар “t_address”
registration_date	Бүртгүүлсэн огноо	Огноо
registration_number	Бүртгэлийн дугаар	500 тэмдэгт
Identification_number	Бичиг баримтын дугаар	500 тэмдэгт
Comments	Нэмэлт тайлбар	4000 тэмдэгт

## 9. Талбар “t\_person\_my\_client”

Нэр	Тайлбар	Төрөл
<b>gender</b>	Хүйс	Сонголт
Title	Хэргэм	30 тэмдэгт
<b>first_name</b>	Өөрийн нэр	100 тэмдэгт
<b>middle_name</b>	Овог	100 тэмдэгт
prefix	Угтвар	100 тэмдэгт
<b>last_name</b>	Эцэг/Эхийн нэр	100 тэмдэгт
<b>birthdate</b>	Төрсөн огноо	Огноо
birth_place	Төрсөн газар	255 тэмдэгт
mothers_name	Эхийн нэр	100 тэмдэгт
alias	Бусад нэр	100 тэмдэгт

<b>SSN</b>	Регистрийн дугаар	25 тэмдэгт
<b>passport_number</b>	Паспортын дугаар	25 тэмдэгт
<b>passport_country</b>	Паспортын улс	25 тэмдэгт
id_number	Үнэмлэхний дугаар	25 тэмдэгт
<b>nationality1</b>	Харьяалал	Сонголт
nationality2	Харьяалал	Сонголт
<b>nationality3</b>	Төрсөн улс	Сонголт
residence	Оршин суугаа улс	Сонголт
<b>phones</b>	Утас	
<b>phone</b>	Утас дэлгэрэнгүй	Талбар <b>"t_phone"</b>
<b>addresses</b>	Хаяг	
<b>address</b>	Хаяг дэлгэрэнгүй	Талбар <b>"t_address"</b>
email	Имэйл	Талбар <b>"email_address"</b>
<b>occupation</b>	Албан тушаал	255 тэмдэгт
<b>employer_name</b>	Ажил олгогчийн нэр	255 тэмдэгт
employer_address_id	Ажил олгогчийн хаяг	Талбар <b>"t_address"</b>
employer_phone_id	Ажил олгогчийн утас	Талбар <b>"t_phone"</b>
identification	Бүртгэл	Талбар <b>"t_person_identification"</b>
deceased	Нас барсан	Булеан
deceased_date	Нас барсан огноо	Огноо
tax_number	Татвар төлөгчийн дугаар	100 тэмдэгт
tax_reg_number	Татвар төлөгчийн бүртгэлийн дугаар	100 тэмдэгт
source_of_wealth	Хөрөнгийн эх үүсвэр	255 тэмдэгт
comments	Тайлбар	4000 тэмдэгт

### 10. Талбар **"t\_person"**

Нэр	Тайлбар	Төрөл
gender	Хүйс	Сонголт
title	Хэргэм	30 тэмдэгт
<b>first_name</b>	Өөрийн нэр	100 тэмдэгт
middle_name	Овог	100 тэмдэгт
prefix	Угтвар	100 тэмдэгт
<b>last_name</b>	Эцэг/Эхийн нэр	100 тэмдэгт
birthdate	Төрсөн огноо	Огноо
birth_place	Төрсөн газар	255 тэмдэгт
mothers_name	Эхийн нэр	100 тэмдэгт
alias	Бусад нэр	100 тэмдэгт
SSN	Регистрийн дугаар	25 тэмдэгт
passport_number	Паспортын дугаар	25 тэмдэгт
passport_country	Паспортын улс	25 тэмдэгт
id_number	Үнэмлэхний дугаар	25 тэмдэгт



<b>phones</b>	Утас	Сонголт
<b>phone</b>	Утас дэлгэрэнгүй	Талбар “ <b>t_phone</b> ”
addresses	Хаяг	Сонголт
address	Хаяг дэлгэрэнгүй	Талбар “ <b>t_address</b> ”
nationality1	Харьяалал	Сонголт
nationality2	Харьяалал	Сонголт
nationality3	Төрсөн улс	Сонголт
residence	Оршин суугаа улс	Сонголт
email	Имэйл	Талбар “ <b>email_address</b> ”
occupation	Албан тушаал	255 тэмдэгт
employer_name	Ажил олгогчийн нэр	255 тэмдэгт
employer_address_id	Ажил олгогчийн хаяг	Талбар “ <b>t_address</b> ”
employer_phone_id	Ажил олгогчийн утас	Талбар “ <b>t_phone</b> ”
identification	Бүртгэл	Талбар “ <b>t_person_identification</b> ”
deceased	Нас барсан	Булеан
deceased_date	Нас барсан огноо	Огноо
tax_number	Татвар төлөгчийн дугаар	100 тэмдэгт
tax_reg_number	Татвар төлөгчийн бүртгэлийн дугаар	100 тэмдэгт
source_of_wealth	Хөрөнгийн эх үүсвэр	255 тэмдэгт
comments	Тайлбар	4000 тэмдэгт

### 11. Талбар “**t\_entity\_my\_client**”

Нэр	Тайлбар	Төрөл
<b>name</b>	Нэр	255 тэмдэгт
commercial_name	Арилжааны нэр	255 тэмдэгт
<b>incorporation_legal_form</b>	Хуулийн этгээдийн төрөл	Талбар “ <b>legal_form_type</b> ”
<b>incorporation_number</b>	Улсын бүртгэлийн дугаар	255 тэмдэгт
<b>business</b>	Бизнес, үйл ажиллагаа	255 тэмдэгт
<b>phones</b>	Утас	Сонголт
<b>phone</b>	Утас дэлгэрэнгүй	Талбар “ <b>t_phone</b> ”
<b>addresses</b>	Хаяг	Сонголт
<b>address</b>	Хаяг дэлгэрэнгүй	Талбар “ <b>t_address</b> ”
email	Имэйл	255 тэмдэгт
url	Веб	255 тэмдэгт
incorporation_state	Үүсгэн байгуулсан муж	255 тэмдэгт
<b>incorporation_country_code</b>	Үүсгэн байгуулсан улс	Сонголт

<b>director_id</b>	Удирдлага	Талбар “t_person”
<b>Role</b>	Эрх үүрэг	Сонголт
<b>incorporation_date</b>	Үүсгэн байгуулсан огноо	Огноо
business_closed	Татан буулгасан	Булеан
date_business_closed	Татан буулгасан огноо	Огноо
tax_number	Татварын дугаар	100 тэмдэгт
<b>tax_reg_number</b>	Татвар төлөгчийн дугаар	100 тэмдэгт
comments	Тайлбар	4000 тэмдэгт

## 12. Талбар “t\_entity”

Нэр	Тайлбар	Төрөл
<b>name</b>	Нэр	255 тэмдэгт
commercial_name	Арилжааны нэр	255 тэмдэгт
incorporation_legal_form	Хуулийн этгээдийн төрөл	Сонголт
incorporation_number	Улсын бүртгэлийн дугаар	50 тэмдэгт
business	Бизнес, үйл ажиллагаа	255 тэмдэгт
phones	Утас	Сонголт
phone	Утас дэлгэрэнгүй	Талбар “t_phone”
addresses	Хаяг	Сонголт
address	Хаяг дэлгэрэнгүй	Талбар “t_address”
email	Имэйл	255 тэмдэгт
url	Веб	255 тэмдэгт
incorporation_state	Үүсгэн байгуулсан муж	255 тэмдэгт
incorporation_country_code	Үүсгэн байгуулсан улс	Enumeration
<b>director_id</b>	Удирдлага	Талбар “t_person”
<b>Role</b>	Эрх үүрэг	Сонголт
<b>incorporation_date</b>	Үүсгэн байгуулсан огноо	Огноо
business_closed	Татан буулгасан	Булеан
date_business_closed	Татан буулгасан огноо	Огноо
tax_number	Татварын дугаар	100 тэмдэгт
tax_reg_number	Татвар төлөгчийн дугаар	100 тэмдэгт
comments	Тайлбар	4000 тэмдэгт

## 13. Талбар “t\_account\_my\_client”

Нэр	Тайлбар	Төрөл
<b>institution_name</b>	Санхүүгийн байгууллагын нэр	255 тэмдэгт

<b>institution_code</b>	Санхүүгийн байгууллагын код	50 тэмдэгт
<b>SWIFT</b>	СВИФТ	11 тэмдэгт
non_bank_institution	Банк бус байгууллага?	Булеан
<b>branch</b>	Салбар	255 тэмдэгт
<b>account</b>	Дансны дугаар	50 тэмдэгт
<b>currency_code</b>	Дансны валют	Сонголт
account_name	Дансны нэр	255 тэмдэгт
iban	ИБАН	34 тэмдэгт
client_number	Харилцагчийн дугаар	30 тэмдэгт
<b>personal_account_type</b>	Дансны төрөл	Сонголт
<b>t_entity</b>	Хуулийн этгээдийн мэдээлэл	Талбар “t_entity_my_client”
<b>signatory</b>	Гарын үсэг зурах эрхтэй хүн	-
<b>is_primary</b>	Үндсэн гарын үсэг зурах эрх	Булеан
<b>t_person</b>	Хүний тухай мэдээлэл	Талбар “t_person_my_client”
<b>role</b>	Эрх үүрэг	Талбар “account_person_role_type”
<b>opened</b>	Данс нээсэн огноо	Огноо
closed	Данс хаасан огноо	Огноо
balance	Дансны үлдэгдэл	Бутархай тоо
date_balance	Балансын огноо	Огноо
<b>status_code</b>	Дансны төлөв	Сонголт
beneficiary	Дансны эцсийн өмчлөгч	50 тэмдэгт
beneficiary_comment	Тайлбар	255 тэмдэгт
comments	Ерөнхий тайлбар	4000 тэмдэгт

#### 14. Талбар “t\_account”

Нэр	Тайлбар	Төрөл
<b>institution_name</b>	Санхүүгийн байгууллагын нэр	255 тэмдэгт
<b>institution_code</b>	Санхүүгийн байгууллагын код	50 тэмдэгт
<b>swift</b>	СВИФТ	11 тэмдэгт
non_bank_institution	Банк бус байгууллага?	Булеан
branch	Салбар	255 тэмдэгт
<b>account</b>	Дансны дугаар	50 тэмдэгт
currency_code	Дансны валют	Сонголт
account_name	Дансны нэр	255 тэмдэгт
iban	ИБАН	34 тэмдэгт
client_number	Харилцагчийн дугаар	30 тэмдэгт

personal_account_type	Дансны төрөл	Сонголт
t_entity	Хуулийн этгээдийн мэдээлэл	Талбар “t_entity”
signatory	Гарын үсэг зурах эрхтэй хүн	-
is_primary	Үндсэн гарын үсэг зурах эрх	Булеан
t_person	Хүний тухай мэдээлэл	Талбар “t_person”
role	Эрх үүрэг	Талбар “account_person_role_type”
opened	Данс нээсэн огноо	Огноо
closed	Данс хаасан огноо	Огноо
balance	Дансны үлдэгдэл	Бутархай тоо
date_balance	Балансын огноо	Огноо
status_code	Дансны төлөв	Сонголт
beneficiary	Дансны эцсийн өмчлөгч	50 тэмдэгт
beneficiary_comment	Дансны эцсийн өмчлөгчийн тайлбар	255 тэмдэгт
comments	Ерөнхий тайлбар	4000 тэмдэгт

### 15. Талбар “t\_person\_registration\_in\_report”

Нэр	Тайлбар	Төрөл
gender	Хүйс	Сонголт
title	Хэргэм	30 тэмдэгт
first_name	Өөрийн нэр	100 тэмдэгт
middle_name	Ургийн Овог	100 тэмдэгт
prefix	Угтвар	100 тэмдэгт
last_name	Эцэг/Эхийн нэр	100 тэмдэгт
birthdate	Төрсөн огноо	Огноо
Birth_place	Төрсөн газар	255 тэмдэгт
mothers_name	Эхийн нэр	100 тэмдэгт
alias	Бусад нэр	100 тэмдэгт
SSN	Регистрийн дугаар	25 тэмдэгт
passport_number	Паспортын дугаар	25 тэмдэгт
passport_country	Паспортын улс	25 тэмдэгт
id_number	Үнэмлэхний дугаар	25 тэмдэгт
Phones	Утас	Сонголт
Phone	Утас дэлгэрэнгүй	Талбар “t_phone”
Addresses	Хаяг	Сонголт
Address	Хаяг дэлгэрэнгүй	Талбар “t_address”
Nationality1	Харьяалал	Сонголт
Nationality2	Харьяалал	Сонголт
Nationality3	Төрсөн улс	Сонголт
residence	Оршин суугаа улс	Сонголт
Email	Имэйл	Талбар “email_address”
Occupation	Албан тушаал	255 тэмдэгт

employer_name	Ажил олгогчийн нэр	255 тэмдэгт
employer_address_id	Ажил олгогчийн хаяг	Талбар “t_address”
employer_phone_id	Ажил олгогчийн утас	Талбар “t_phone”
identification	Бүртгэл	Талбар “t_person_identification”
deceased	Нас барсан	Булеан
deceased_date	Нас барсан огноо	Огноо
tax_number	Татвар төлөгчийн дугаар	100 тэмдэгт
tax_reg_number	Татвар төлөгчийн бүртгэлийн дугаар	100 тэмдэгт
source_of_wealth	Хөрөнгийн эх үүсвэр	255 тэмдэгт
comments	Тайлбар	4000 тэмдэгт

### 16. Талбар “t\_party”

Нэр	Тайлбар	Төрөл
role	Гүйлгээнд оролцсон байдал	Сонголт
Person	Ороцсон хүн	Талбар “t_person”
Person_my_client	Ороцсон хүн (миний харилцагч)	Талбар “t_person_my_client”
account	Ороцсон данс	Талбар “t_account”
account_my_client	Ороцсон данс (миний харилцагчийн)	Талбар “t_account_my_client”
entity	Ороцсон этгээд	Талбар “t_entity”
entity_my_client	Ороцсон этгээд (миний харилцагч этгээд)	Талбар “t_entity_my_client”
funds_code	Гүйлгээг хийсэн Хөрөнгийн хэлбэр	Сонголт
funds_comment	Хөрөнгийн хэлбрийн тайлбар	255 тэмдэгт
foreign_currency	Бусад улсын валютаар хийсэн бол	Талбар t_foreign_currency
country	Гүйлгээ хийсэн улс	Сонголт
significance	Хийсэн хүний оролцоо	Бүхэл тоо
comments	Ерөнхий тайлбар	4000 тэмдэгт

### 17. Талбар “t\_address”

Нэр	Тайлбар	Төрөл
address_type	Хаягын төрөл	Сонголт
address	Хаяг	100 тэмдэгт
town	Хаяг	255 тэмдэгт
city	Хот/Аймаг	255 тэмдэгт
zip	Зип код	10 тэмдэгт
country_code	Улс	Сонголт
State	Муж	255 тэмдэгт

### 18. Талбар “t\_phone”

Нэр	Тайлбар	Төрөл
<b>tph_contact_type</b>	Холбооны төрөл	Сонголт
<b>tph_communication_type</b>	Утасны төрөл	Сонголт
tph_country_prefix	Улсын код	4 тэмдэгт
<b>tph_number</b>	Утасны дугаар	50 тэмдэгт
tph_extension	Дотуур утасны дугаар	10 тэмдэгт
comments	Тайлбар	4000 тэмдэгт

### 19. Талбар “t\_foreign\_currency”

Нэр	Тайлбар	Төрөл
<b>foreign_currency_code</b>	Валютын нэгжийн код ISO 4217 дагуу	Сонголт
<b>foreign_amount</b>	Гадаад валютын дүн	Бутархай тоо
<b>foreign_exchange_rate</b>	Гүйлгээнд ашигласан ханш	Бутархай тоо

### 20. Талбар “t\_person\_identification”

Нэр	Тайлбар	Төрөл
<b>type</b>	Төрөл	Сонголт
<b>number</b>	Дугаар	255 тэмдэгт
issue_date	Олгосон огноо	Огноо
expiry_date	Дуусах огноо	Огноо
issued_by	Олгосон эрх бүхий байгууллага	255 тэмдэгт
<b>issue_country</b>	Олгосон улс	Сонголт
comments	Тайлбар	4000 тэмдэгт

### 21. Талбар “report\_party\_type”

Нэр	Тайлбар	Төрөл
<b>person</b>	Ороцсон хүн	Талбар “t_person”
<b>account</b>	Ороцсон данс	Талбар “t_account”
<b>entity</b>	Ороцсон этгээд	Талбар “t_entity”
significance	СГТ-нд хамаарах ач холбогдол	Бүхэл тоо
reason	Үндэслэл	4000 тэмдэгт
comments	Тайлбар/Арга хэмжээ	4000 тэмдэгт